



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН МЭЭЖ ОНӨХХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2023/02/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Баталгаат тооцоолол аудит ХХК
Захирал: М.Буянбулган
Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАРЧИГ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. АУДИТЫН ТАЙЛАН	6
4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ .	12
6. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	13
7. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ	13
8. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
8.1 Төлбөрийн акт.....	14
8.2 Албан шаардлага	14
8.3 Зөвлөмж.....	14
9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БУА	Булган аймаг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдугаар орон чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.03.15 № 273

танай _____ ны № _____ т

"БУЛГАН МЭЭЖ" ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ГАНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Булган Мээж" Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Булган Мээж" орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрт тусгагдсан Хэрэгцээний халуун усыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2 үе шаттайгаар хэрэгжүүлж 9 байр, 2 цэцэрлэг, 1 сургуулийг хэрэгцээний халуун усаар хангах, Монгол улс Азийн хөгжлийн банкны зээлийн хэлэлцээрийн хүрээнд тус аймагт хэрэгжүүлэх Нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах бүрэлдэхүүн хэсгийн төсөлд дамжуулан зээлдүүлэх гэрээг аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан.

Аудитын гол асуудал

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 594 дугаар тогтоолын дагуу 875,606.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ

D:\bichigheg\2023\41001

006020274

төлбөргүйгээр орлогод авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 10 дугаар тогтоолын дагуу 14,500.0 мянган төгрөгийн суудлын автомашин, компанийн захирлын 7 дугаар сарын 08-ны өдрийн А/48 дугаар тушаалаар 8 нэр төрлийн 597.8 мянган, 2023 оны 01 дүгээр сарын 24-ний А/09 дугаар тушаалаар 52 нэр төрлийн 6,169.1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлах шийдвэр гаргаж, данснаас хасалт хийсэн.

Үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 459 дүгээр тогтоолоор нэмэгдүүлсэн нь төсөвт байгууллагуудад оны эцэст авлага үүсэхэд хүргэсэн. 2022 оны 445 дугаар тогтоолоор 01 дүгээр сарын 01-нээс 9 дүгээр сарын 15-ныг хүртэл хугацаанд бууруулахаар өөрчилсөн байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд компанийн гүйцэтгэх захирал аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 6 зорилтын 24 арга хэмжээ төлөвлөснийг 84.6 хувийн биелэлттэй хэрэгжүүлж ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

© /bichigwang/2023/4/4/001

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2021.12.31	2022.12.31
01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	162,233,035.14	165,098,798.33
02	Дансны авлага	706,782,219.61	756,770,528.27
03	Татварын НӨАТ авлага	130,563,908.58	375,311,394.68
04	Бусад авлага	6,991,607.28	73,057,863.68
05	Бараа материал	7,036,397,430.83	7,066,093,908.47
06	Бусад эргэлтийн хөрөнгө	42,348,935.36	42,348,935.36
07	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,085,317,136.80	8,478,681,428.79
08	Үндсэн хөрөнгө	11,142,513,397.22	11,170,647,541.00
09	Биет бус хөрөнгө	6,000,000.00	3,000,000.00
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,148,513,397.22	11,173,647,541.00
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,233,830,534.02	19,652,328,969.79
12	Дансны өглөг	2,731,048,164.12	4,045,053,174.80
13	Татварын өр	3,054,708.54	206,321,602.55
14	Урьдчилж орсон орлого	8,382,562.41	5,056,226.05
15	Нөөц /өр төлбөр/	4,813,157.00	4,813,157.00
16	Бусад богино хугацаат өр төлбөр	790,053.01	0.00
17	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,748,088,645.08	4,261,244,160.40
18	Урт хугацаат зээл	10,219,647,991.55	10,219,647,991.55
19	Нөөц /өр төлбөр/	136,309.09	136,309.09
20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,219,784,300.64	10,219,784,300.64
21	Өр төлбөрийн нийт дүн	12,967,872,945.72	14,481,028,461.04
22	Өмч: - төрийн	9,290,694,877.55	10,132,903,076.15
23	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	381,177,427.96	381,177,427.96
24	Хуримтлагдсан ашиг	-3,405,914,717.21	-5,342,779,995.36
25	Тайлангийн үеийн ашиг	0.00	-1,921,748,630.87
26	Өмнөх үеийн ашиг	-3,405,914,717.21	-3,421,031,364.49
27	Эздийн өмчийн дүн	6,265,957,588.30	5,171,472,870.87
28	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,233,830,534.02	19,652,328,969.79

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	4,660,639,332.31	6,117,598,426.29
02	Борлуулалтын өртөг	6,069,150,592.63	8,120,945,718.22
03	Нийт ашиг(алдагдал)	(1,408,511,260.32)	(2,003,347,291.93)
04	Түрээсийн орлого	6,335,908.00	5,312,000.00
05	Хүүний орлого	1,307,831.58	6,041,661.50

06	Бусад орлого	354,504,283.79	558,619,024.54
07	Орлогын дүн	362,148,023.37	569,972,686.04
08	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
09	Ерөнхий ба удирдлагын зардал	356,716,308.47	380,960,178.89
10	Бусад зардал	0.00	23,970,056.30
11	Зардлын дүн	356,716,308.47	404,930,235.19
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(2,013,888.82)
13	Бусад ашиг (алдагдал)	(403,158,482.56)	(81,429,900.97)
14	Олз, гарзын дүн	(403,158,482.56)	(83,443,789.79)
15	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(1,806,238,027.98)	(1,921,748,630.87)
16	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,806,238,027.98)	(1,921,748,630.87)
17	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,806,238,027.98)	(1,921,748,630.87)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,053,813,557.36	7,205,659,023.58
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,570,463,585.67	6,619,331,795.74
1.1.2	Татаас, санхүүжилтийн орлого	59,745,935.10	253,435,182.66
1.1.3	Бусад мөнгөн орлого	423,604,036.59	332,892,045.18
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,969,782,752.34	7,161,996,135.39
1.2.1	Ажиллагчдад төлсөн	686,061,363.00	862,275,019.43
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	239,821,370.15	229,388,045.02
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	526,346,337.32	370,002,731.77
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,731,708,550.34	5,018,787,084.61
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	157,316,980.00	173,125,623.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	318,111.30
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	179,686,648.14	217,591,554.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	1,269,337.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	448,841,503.39	289,238,628.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	84,030,805.02	43,662,888.19
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	59,793,181.82	40,797,125.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	59,793,181.82	40,797,125.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,076.26	0.00
3.1.1	Бусад	20,076.26	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	24,257,699.46	2,865,763.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,975,335.68	162,233,035.14
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	162,233,035.14	165,098,798.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	7,729,781,236.18	-3,405,914,717.21	6,265,957,588.30

02	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	(15,116,647.28)	(15,116,647.28)
03	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(1,921,748,630.87)	(1,921,748,630.87)
04	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	842,208,198.60	0.00	842,208,198.60
05	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	8,571,989,434.78	(5,342,779,995.36)	5,171,300,508.75

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Шугам хоолойн цэвэр ус	мян.м3	125.6	113.8	109.1	-4.8	95.9
2	Бохир ус татан зайлуулах	мян.м3	213.9	94.9	152.3	57.3	160.5
3	Тээврийн цэвэр ус	мян.м3	12.7	28.8	15.4	-13.5	53.4
4	Түгээсэн дулаан	мян.гкал	31.9	31.4	38.2	6.8	121.7

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган Мээж ОНӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Булган Мээж ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр баримтуудын хамт жагсаалтаар хүлээлгэн өгсөн.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 05-аас 17-ны хооронд Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, Г.Цогтбаатар гүйцэтгэж, хяналтыг захирал М.Буянбулган хэрэгжүүлсэн.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай гэж үзсэн. Үүнд: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж ажиллаагүй, аймгийн ЗДТГ-тай төслийн дамжуулан зээлдэх гэрээний төслийн зориулалт, төлбөр, тооцооны гэх мэт асуудлууд нь ойлгомжтой, тодорхой бус, ТУЗ, дотоод хяналтын нэгж санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дотоод хяналт шалгалт хийгээгүй зэргийг үндэслэл болгож байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Булган Мээж ОНӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 7,161,996.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 143,239.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 30 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрэмд “Булган Мээж” ОНӨХХК нь хэрэглэгчийн эрх ашгийг эрхэмлэн хүндэлж, стандартын шаардлагад нийцсэн цэвэр ус, дулааны эрчим хүчээр хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах дор дурьдсан үндсэн үйл ажиллагааг үндсэн зорилгоо болгоно гэж тодорхойлжээ. Үүнд:

1. Дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах;
2. Цэвэр ус олборлох, цэвэр усыг хэрэглэгчид ус дамжуулах шугам сүлжээгээр болон тусгай зориулалтын машинаар зөөвөрлөн хэрэглэгчид хүргэж үйлчилэх
3. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын бохирыг татан зайлуулах
4. Дээрх үйлчилгээнд ашигагдаж буй шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ, түүнд тавих хяналтын үйчилгээ
5. Барилга угсралт
6. Халуун ус, хими цэвэрлэгээ болон бусад шаардлагатай үйчилгээ
7. Бетон, төмөр бетон эдэ, зуурмаг, барилгын чулуун материал бүтээгдэхүүн үйлдвэрлэл

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 30 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмээр “Булган Мээж” ОНӨХХК ба үүсгэн байгуулагч нь аймгийн ИТХ буюу 100 хувийн орон нутгийн өмчит хуулийн этгээд болно.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12-т: *Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх* гэсэн заалттай нийцэж байна.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор баталсан компанийн дүрэмд тодорхойсон Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон

байгууллагын үй ажиллагаанд хамааралтай Засгийн газрын тогтоолууд, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрүүдийг мөрдлөг болгодог байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар тогтоолоор томилсон нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэж байна.

Гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг даргын 2020 оны Б/85 тоот захирамжаар томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т: “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заалт, өнгөрсөн оны аудитаар өгсөн албан шаардлагын дагуу аймгийн ЗДТГ-тай төлөвлөгөөг талууд хамтран байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор шинэчлэн батласныг мөрдлөг болгон ажиллаж ирсэн ба 2022 оны 11 сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолоор дахин шинэчилжээ. Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	162,233.0	165,098.8	2,865.8
Авлага	844,337.7	1,205,139.8	360,802.1
Бараа материал	7,078,746.4	7,108,442.9	29,696.5
Үндсэн хөрөнгө	11,148,513.4	11,173,647.5	25,134.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,233,830.5	19,652,329.0	418,498.5
Богино хугацаат өглөг	2,748,088.6	4,261,244.2	1,513,155.6
Урт хугацаат өглөг	10,219,784.3	10,219,784.3	0.0
Эздийн өмч	6,265,957.6	5,171,300.5	(1,094,657.1)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,233,830.5	19,652,329.0	418,498.5

4.3.1 Мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	2022.01.01	2022.12.31
Касс дахь дахь бэлэн мөнгө	41.3	1,016.8
Банкин дахь мөнгө	162,186.7	164,082.0
Нийт дүн	162,228.0	165,098.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн касс дахь бэлэн мөнгө 1,016.7 мянган төгрөг болж, өнгөрсөн оноос 975.4 мянгаар өссөн.

Банк дахь харилцах дансанд 164,082.0 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас Хаан банкны гурван харилцахад 51,601.9 мянган, Төрийн банкинд хоёр харилцах дансанд 9,479.2 мянган, Төрийн банкны хугацаатай хадгаламжид 101,188.1 мянган, Хас банкны харилцахад 1,812.8 мянган төгрөг байна.

4.3.2 ДАНСНЫ АВЛАГА

Эхний үлдэгдэл	706,782.2
нэмэгдсэн	7,315,776.9
хасагдсан	7,265,788.6
Эцсийн үлдэгдэл	756,770.5

Авлагын үлдэгдэлд аж ахуй нэгж байгууллагын 729,858.7 мянган, айл өрхийн 26,911.8 мянган төгрөг байгаа ба өнгөрсөн оноос 49,988.3 мянгаар өсчээ.

Эхний үлдэгдлийн 182,349.1 мянган төгрөгийн авлага нь 2021 оны ЭХЗХ-ны 459 дугаар тогтоолоор баталсан Хэрэглэгчдэд борлуулах эрчим хүчний тарифийн өөрчлөлтэй холбоотойгоор үүссэн байна. Булган аймаг дахь ТАГ 2022 онд гүйцэтгэлийн аудит хийхдээ 02/329 дугаар албан шаардлагаар шийдвэрлүүлэхийг компанийн удирдлагад даалгажээ. Хэрэгжилтийг шалгахад 10,403.4 мянган төгрөгөөр бууруулж, 171,945.7 мянган төгрөгийг бүрэн шийдвэрлээгүй байна.

4.3.3 ТАТВАРЫН АВЛАГА

НӨАТ-ийн хэрэгжээгүй авлагын дүн 375,311.4 төгрөгийн үлдэгдэл байгаагаас Үндсэн хөрөнгө (машин тоног төхөөрөмж) худалдан авахтай холбоотой хувь тэнцүүлсэн 7,579.3 мянган, “Энержи Плас” ХХК-ийн хэрэгжээгүй 367,732.1 мянган төгрөг байна.

4.3.4 БУСАД АВЛАГА

	/мянган төгрөг/
Эхний үлдэгдэл	6,991.6
Нэмэгдсэн	325,678.4
Хасагдсан	259,612.1
Эцсийн үлдэгдэл	73,057.9

Бусад авлага нь тайлант хугацаанд 66,066.3 мянган төгрөгөөр өсчээ. Үүнд дулааны засвар, цэвэр бохир усны засвар үйлчилгээний орлого 66,6, тендерээр хийсэн ажил болон гэрээт ажлын орлого 29, өмгөөлөгчийн ажлын хөлс 4,4 хувийг эзэлж байна.

Найдваргүй авлагыг хасагдуулга аргаар тооцдог ба нийт авлагын үлдэгдлийн 857,376.0 мянган төгрөг хэвийн байна. Тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй.

4.3.5 БАРАА МАТЕРИАЛ

	/мянган төгрөг/			
Бараа материалын төрөл	2022.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
Аж ахуйн материал	34,226.3	58,591.6	58,274.0	34,543.9
Маягт ном	1,404.7	10,065.0	198.1	11,271.6
Түлш	3,525.0	99,307.1	97,339.4	5,492.7
Шатах тослох материал	5,555.8	173,368.6	174,519.7	4,404.8
Барилгын материал	18,336.2	29,359.7	36,404.4	11,291.5
Цахилгааны сэлбэг	5,771.0	8,458.9	8,514.5	5,715.4
Сантехникийн сэлбэг	84,241.6	69,230.6	62,357.2	91,115.1
Сантехникийн хуучин тоног төхөөрөмж	8,293.7	0.0	0.0	8,293.7
Сантехникийн материал/Төсөл/	7,353.3	0.0	0.0	7,353.3
Тендерийн материал	1,991.8	65,040.5	66,101.5	930.8

Авто сэлбэг	5,490.2	29,599.1	28,341.6	6,747.7
Хангамжийн материал	83,579.6	23,145.3	6,496.3	100,228.6
ДҮН	259,769.1	566,166.5	538,546.5	287,389.0

Бараа материал өмнөх оноос 27,619.9 мянган төгрөгөөр өссөн ба ном маягт НБББББ 36, хангамжийн материал 64 хувийг эзэлж байна.

4.3.6 ДУУСААГҮЙ БАРИЛГА

Бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэлд Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл"-ийн хүрээнд аймгийн төвд баригдсан 3000 м3/хоногийн хүчин чадалтай 6,776,628.4 мянган төгрөгийн цэвэрлэх байгууламжийн барилга тайлагнагдсан. Тайлант хугацаанд цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээнд 2,076.6 мянган төгрөгийн зардлыг хуримтлуулж бүртгэсэн байна.

Мөн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлд ашиглалтгүй 42,348.9 мянган төгрөгийн бараа материалыг борлуулах зорилгоор эзэмшиж гэсэн нийтлэг бус ангилалаар бүртгэсэн байна.

4.3.7 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө /Өртөг	Барилга байгууламж	Машин, тоног төхөөрөмж	(мянган төгрөг)		Нийт дүн
			Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	
Эхний үлдэгдэл	6,508,296.2	7,422,313.9	515,043.0	92,501.6	14,445,653.0
нэмэгдсэн	0.0	875,906.8	24,500.0	15,340.0	900,406.8
хасагдсан	0.0		14,500.0	107,841.6	122,341.6
Эцсийн үлдэгдэл	6,508,296.2	8,298,220.7	525,043.0	0.0	-107,841.6
Хуримтлагдсан элэгдэл					0.00
Эхний үлдэгдэл	374,233.4	3,115,564.9	409,532.6	35,599.3	3,899,330.9
нэмэгдсэн	307,290.2	516,323.6	44,855.1	17,129.9	815,739.6
хасагдсан	0.0		12,486.1		12,486.1
Эцсийн үлдэгдэл	681,523.6	3,631,888.5	441,901.6	52,729.3	681,523.6

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,170,647.5 мянган төгрөг болоход дараах үйл явц нөлөөлсөн байна. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дулаан дамжуулах төвүүдэд ашиглагдах **875,906.8** мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн нь нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалалтын төлөвлөгөөний дагуу 24,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 15,340.0 мянган төгрөгийн компьютер, дэлгэц, проектор худалдан авсан, ИТХ-ын 2022 оны 6 сарын 23-ний өдрийн 10 дугаар тогтоолоор 14,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл акталсантай зэрэгтэй холбоотой байна.

4.3.8 БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгө	Компьютерийн программ хангамж	(мянган төгрөг)	
		Нийт дүн	
Эхний үлдэгдэл		9,000.0	9,000.0
Хуримтлагдсан элэгдэл		6,000.0	6,000.0
Эцсийн үлдэгдэл		3,000.0	3,000.0

4.3.9 ДАНСНЫ ӨГЛӨГ

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 4,261,244.2 мянган төгрөг болж өнгөрсөн оноос 1,314,005.0 мянган төгрөгөөр өссөн нь Энержи Плас ХХК-д төлөх өглөгтэй хамааралтай байна.

4.3.10 ТАТВАРЫН ӨР

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	НӨАТ	ХХОАТ	Нийт
Эхний үлдэгдэл	0.0	3,054.7	3,054.7
Нэмэгдсэн	831,791.1	76,175.8	907,967.0
Хасагдсан	628,230.3	76,469.8	704,700.1
Эцсийн үлдэгдэл	203,560.9	2,760.7	206,321.6

4.3.11 УРЬДЧИЛЖ ОЛСОН ОРЛОГО

	/мянган төгрөг/
Эхний үлдэгдэл	8,382.6
Нэмэгдсэн	66,623.1
Хасагдсан	69,949.5
Эцсийн үлдэгдэл	5,056.2

Урьдчилж осон орлого буурахад шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр үйлчилгээний машины (75-75 БУЛ) холбоотой орлого 1,500.00 мянган төгрөгөөр, “Заг Инженеринг” ХХК-ийн цэцэрлэгжүүлэлтийн улирлын урьдчилгаа төлбөр 780.5 мянган төгрөгөөр, дулаан усны урьдчилгаа төлбөр 2,775.7 мянган төгрөгөөр буурч, ЭХЗХ-ний 2022 оны 7 сарын 26-ний өдрийн 445 тоот тогтоолоор үнийн тарифт өөрчлөлт орсон зэрэг нь нөлөөлсөн байна.

4.3.12 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Урт хугацаат өр төлбөр данс дахь 10,219,784.3 мянган төгрөг нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хот байгуулалтын салбарын “МОН-2301, 2014-2036 оныг дуустал 22 жилд, “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төслийн дамжуулан зээлдэх гэрээний мөнгийг 2025-2038 он дуустал 13 жилд төлөх хуваарьтай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь Сангийн яам зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан, барилга байгууламжийн ашиглалтыг жигдрүүлэхтэй холбоотой байна.

4.3.13 НӨӨЦ, ӨР ТӨЛБӨР

Хамтын гэрээний дагуу тайлант хугацаанд ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгө 2,380.00 -өөр нэмэгдэж зарцуулалт 2,380.00 төгрөгийн зарцуулалттай байна.

4.3.14 ОРЛОГО

№	Үйл ажиллагааны зардал	2021 он	2022 он			Харьцуулалт
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	4,625,812.2	6,611,095.6	6,038,385.4	(572,710.2)	(1,412,573.2)
2	Бусад орлого	8,809.3	18,447.9	18,874.9	427.0	(10,065.6)
3	Бусад орлого	46,658.4	47,805.1	60,338.1	12,533.0	(13,679.7)
4	Үндсэн үйл ажиллагааны орлого	4,625,812.2	6,611,095.6	6,038,385.4	(572,710.2)	(1,412,573.2)
НИЙТ ДҮН		4,681,280.0	6,677,348.7	6,117,598.4	(559,750.2)	(1,436,318.5)

4.3.15 ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	2021 он	2022 он
---	----------	---------	---------

		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	2021 онтой харьцуулвал
1	Цалин хөлс	969,997.2	1,190,805.1	1,128,254.1	62,551.0	86%
2	Ашиглалтын зардал	380,323.9	548,251.1	292,818.5	255,432.6	130%
3	Засвар үйлчилгээний зардал	57,677.6	140,174.3	98,254.2	41,920.1	59%
4	Ажиллагсадтай холбоотой зардал	59,578.5	19,056.0	86,945.8	(67,889.8)	69%
5	Элэгдлийн зардал	659,466.0	556,373.3	888,598.8	(332,225.5)	74%
6	Материалын зардал	260,521.7	184,063.7	200,331.8	(16,267.5)	130%
7	Татвар,даатгал, төлбөр хураамжийн зардал	3,966,577.5	4,208,688.4	5,594,917.2	(1,386,228.9)	71%
8	Бусад зардал	71,422.7	52,936.0	211,786.7	(158,850.2)	34%
	НИЙТ:	6,425,565.1	6,900,347.8	8,501,905.9	(1,601,558.1)	76%

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогоо тусгасан гэх боловч холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлага, шалгууртай нийцээгүй байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Булган Мээж ОНӨХХК үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

2022 оны үйлдвэрлэлийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйц	2022 он				2021 оноос	
				Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
1	Шугам хоолойн цэвэр ус	мян.м3	125.6	113.8	109.1	-4.8	95.9	-16.5	86.9
2	Бохир ус татан зайлуулах	мян.м3	213.9	94.9	152.3	57.3	160.5	-61.6	71.2
3	Тээврийн цэвэр ус	мян.м3	12.7	28.8	15.4	-13.5	53.4	2.7	121.3
4	Түгээсэн дулаан	мян.гкал	31.9	31.4	38.2	6.8	121.7	6.3	119.7

Төлөөлөн удирдах зөвлөл Булган Мээж ОНӨХХК-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтыг 296,282.0 мянган, 03 дугаар тогтоолоор тайлант оны нийт орлогыг 7,021,071.0 мянган, нийт зардлыг 7,020,636.0 мянган, 435.0 мянган төгрөгийн ашигтай ажиллах 2022 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

Гүйцэтгэлээр 7,205,659,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 7,161,996.1 мянган төгрөгийн зардал гарган, 1.178.628.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Үүнд: 2022 оны Эрчим хүчний зохицуулах хорооны 445 дугаар тогтоолоор 01 дүгээр сарын 01-нээс 9 дүгээр сарын 15-ныг хүртэл хугацаанд бууруулахаар өөрчилсөн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант онд алдагдалтай ажилласан тул орон нутгийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлээгүй байна.

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 заалтад хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 заалтад тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд 167 мэдээлэл байрлуулахаас 160-ийг байруулсан ба цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 4 мөнгөн гүйлгээ, санхүүгийн хагас жилийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, мөн 19 буюу 26,701.3 мянган төгрөг тушаалыг мэдээллээгүй, тавигдсан зарим мэдээлэл нь маягтын дагуу бус, шалгаан, тайлбар, шийдвэрийн утга дутуу зэрэг мэдээлэл оруулах зааврыг баримтлаагүй зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1-д: “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Компанийн гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг даргын 2020 оны Б/85 дугаар захирамжаар, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар тогтоолоор томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, Компанийн тухай 75 дугаар зүйлийн 75.3 “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно” заатуудтай нийцэж байна.

- Булган Мээж ОНӨХХК Эрчим хүчний тухай хууль, Засгийн газрын тогтоолууд болон компанийн дүрэмд тодорхойлсон эрхийн актууд, аймгийн ИТХ, Засаг даргын холбогдох тогтоол, захирамжуудыг мөрдлөг болгосон байна гэж үзлээ.

6. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8,779,238.0 мянган төгрөгийн зөрчилд 8,126,116.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 653,121.3 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсний биелэлтийг 100.0 хувь гэж дүгнэлээ.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	8,126,116.7	2	8,126,116.7	100.0
Зөвлөмж	6	653,121.3	6	653,121.3	100.0
Нийт дүн	8	8,779,238.0	8	8,779,238.0	100.0

7. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт болон завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

8. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 335,335.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс эрх зүйн акт зөрчигдсөн² алдааг дахин давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 3 зөвлөмж өгөхөөр аудитийн баг шийдвэрлэсэн.

8.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

8.2 Албан шаардлага

Аудитаар 3 албан шаардлага өгөв.

8.3 Зөвлөмж

Өгсөн зөвлөмж:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт: Компанийн мөрдөж ирсэн НБББББ нь нийтлэг мөрдөгдөж буй холбогдох эрх зүйн актуудын шалгуур, шаардлагыг бүрэн хангахгүй байна. Тухайлбал: НББ-ийн бодлогын дансны нэгдсэн жагсаалтын "Бараа материал" хэсэгт төслийн, тендерийн гэсэн ангилал нэрээр бүртгэл хөтлөлт хийхээр тусгасан нь бараа материалын тайлангийн нэр төрөл болсноос гадна борлуулах зориулалтаар эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө гэсэн ангилалаар тайлагнасан байв.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9, 18.2, 20.2.2 заалтуудыг хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудтай нийцүүлэн шинэчилж, баталгаажуулах

2. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооллогын комисс Сангийн сайдын 2017 оны 347 тогтоолын зааврыг бүрэн мөрдлөг болгоогүй. Тухайлбал: Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан хуваарийн дагуу тооллогын комиссууд тооллогыг хийхдээ үндсэн болон эргэтийн хөрөнгийн чанар байдлын үзүүлэлтийг тодорхой тусгаагүй, зарим тайлбар нь хөрөнгө бодитой байгаа эсэх тодорхойгүй, тооллогын бүртгэлийн нэгжийн үнээр тодорхойлж нэгтгэл хийж баталгаажуулан тооцоо бодсон актыг үйлдээгүй байв.

Энэ нь ТБОНӨТХ-ын 72 дугаар зүйлийн 4.3, 4.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 5.1.5, 13.1 заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 тогтоолын зааврыг хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудын заалт, зааврыг мөрдлөг болгох, дотоод хяналтыг сайжруулах

3. Санхүүгийн тайлангийн түвшинтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нүүрс, хангамжийн материал, түлш шатахуун, бичиг хэргийн материалыг ямар хэлбэрээр худалдан авах тухай шийдвэрийг компанийн захирал албажуулж, баталгаажуулдаггүй..

Энэ нь 2021 оны 124 дугаар Засгийн газрын тогтоолоор баталсан ТБОНӨХБАҮХАТХ-ийн босго үнийн ангиллын заалтыг мөрдлөг болгон ажиллаагүйтэй холбоотой байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудын шаардлага, шалгуурыг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрх зүйн актыг мөрдөөгүй	6	335,335.4	0	0.0	3	198,647.0	3	136,688.4	0	0.0	0	0.0
Дүн	6	335,335.4	0	0.0	3	198,647.0	3	136,688.4	0	0.0	0	0.0